

ХАМТАРСАН БАГ



ХАМТАРСАН БАГИЙН АХЛАГЧ ЗАСАГ ДАРГАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭС
УРЬДЧИЛАН СЭРТГИЛЭХ АНЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВӨЛ



From
the People of Japan

Нэмж засварласан 3 дахь хэвлэлт

© Хүүхдийг ивээх сан (2016, 2019)

© Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк (2023)

Боловсруулсан:

Б.Батхүү (2016, 2019)

Ц.Өнөрцэцэг (2023)

Хянан тохиолдуулсан:

Х.Өлзийтунгалаг

Г.Ойнбаяр

Э.Дуламсүрэн (2016, 2019)

Р.Нарантуяа ХНХЯ (2023)

Г.Амаржаргал ГХУСАЗЗАА (2023)

Гарын авлагын зургийг:

Г.Ганбаяр (2016, 2019, 2023)

Нэмж засварласан 3 дахь хэвлэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран "Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" төслийн санхүүжилтээр хэвлэв.

Гарчиг

Шигтгээ, зураг, хүснэгтийн жагсаалт	4
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХАМТАРСАН БАГИЙН АХЛАГЧ, ЗАСАГ ДАРГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ	7
1.1.Хамтарсан багийн хурал	9
1.2.Хамтарсан багийн хүний нөөц.....	14
1.3.Хамтарсан багийн гишүүдийн аюулгүй байдал	15
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	20
2.1.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээний зураглал	24
2.2.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хүнд үзүүлэх үйлчилгээ.....	25
Ашигласан материал.....	28

ШИГТГЭЭ, ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Бүх шатны ИТХ, Засаг дарга нарын хамтарсан багийн асуудлаар хэрэгжүүлэх чиг үүрэг	8
Зураг 2. Хүчирхийллийн зураглал.....	20
Зураг 3. Гэр бүлийн хүчирхийлийн хохирогчийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийн зураглал.....	21
Зураг 4. Шуурхай тусламжийн үйлчилгээний зураглал	24
Зураг 5. Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ	25
Хүснэгт 1. Хамтарсан багийн гишүүдийн аюулгүй байдлын хяналтын хүснэгт.....	15
Хүснэгт 2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээнд шаардлагатай зардлыг шийдвэрлэх нь.....	18
Хүснэгт 3.Зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ	25
Хүснэгт 4. Хамтарсан багийн гишүүдийн оролцоо	26
Шигтгээ 1. Хамтарсан багийн хүний нөөц	14
Шигтгээ 2. Хамтарсан багийн хүний нөөцийн асуудал.....	14
Шигтгээ 3. Тоо баримтаас.....	22
Шигтгээ 4. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжөөс.....	23
Шигтгээ 5. Жендэрт суурилсан хүчирхийлэл судалгааны тайлангаас	26

ЖЕНДЕРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

“ЖЕНДЕРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл эс эс үйлдэхгүйг хэлнэ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиас

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод хандсан үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг өөрийн эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Биеийг нь үнэлүүлэх бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах. Эд эрхтнийг авах албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлах, хууран мэхлэх итгэл эвдэж. Эрх мэдлээ урвуулан ашиглаж эмзэг байдлыг нь дамжуулж эсхүл бол хяналтдаа байлгаж байгаа хүн төлбөр төлж, хахуульдаж, хүнийг эрхшээлдээ оруулан Элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан үйлдлийг хэлнэ.

АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТ

Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн. Эс л бол харьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан. Мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй Орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл эс үйлдэхгүйг эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх Болгож эдлүүлэх болзол болгон тавихыг хэлнэ.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

1. БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

гэр бүлийн хамаарал бүхий хүний амь нас эрүүл мэндэд гэм хор учруулсан эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдлээс үйлдэхүй хэлнэ.

2. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний эрхшээлтэй байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ.

3. СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг албадан албадах. Үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг

4. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээрийн адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө. Эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах оролд. Орлого олох боломжийг нь хязгаарлах шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах. Тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан эсхүл бол эд хөрөнгийн хохирол учруулсныг хэлнэ

ХАМТАРСАН БАГИЙН АХЛАГЧ, ЗАСАГ ДАРГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан Хамтарсан баг нь өрхийн эмч, сумын нийгмийн ажилтан, хорооны нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, халамжийн нийгмийн ажилтан, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх ба хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахалж ажиллана гэж заасан.

Хамтарсан баг нь салбар хоорондын олон талт хамтын ажиллагааны загвартай, салбар дундын үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий нэгж юм. Салбар дундын олон талт хамтын ажиллагааны хэлбэрийн бүтэц нь хуульд албан ёсоор тусгагдсан харьцангуй шинэлэг загвар билээ.

Хамтарсан баг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:


- гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;
- хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
- нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;
- хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;
- хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх

Хуульд хамтарсан багийг сум, баг, хорооны түвшинд байгуулахаар заасан боловч хохирогчид үзүүлэх үйлчилгээг иргэнд ойр байлгах үүднээс хүн ам ихтэй зарим аймгийн төвийн сумын баг бүрд хамтарсан баг байгуулжээ. Мөн ихэнх засаг захиргааны нэгжид хуулийн дагуу сум, хороо тус бүрд нэг хамтарсан баг ажиллаж байх боловч зарим орон нутагт хоёр багийн дунд нэг хамтарсан баг байгуулжээ¹.

Бүх шатны ИТХ, Засаг дарга, Хамтарсан багийн асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлэхийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан.

¹ ХЭҮК, Хүний эрхийн төлөв байдлын тайлан 2021, 2022 он

Зураг 1. Бүх шатны ИТХ, Засаг дарга нарын хамтарсан багийн асуудлаар хэрэгжүүлэх чиг үүрэг



Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангах ба багийн тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх хүрээнд хамтарсан багийн гишүүний харъяалах байгууллага, агентлагуудтай шууд харьцаж тулгарч буй бэрхшээлийг богино хугацаанд шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Түүнчлэн дээд шатны дараах байгууллагуудаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авч, хамтран ажиллах боломжтой. Үүнд:

- ГХУСАЗЗАА
- Нийгмийн үйлчилгээ, гэр бүл, хүүхдийн халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд
- Эрүүл мэндийн байгууллага
- Хууль сахиулах байгууллага
- Боловсролын байгууллага
- Жендэрийн болон эмэгтэйчүүдийн ТББ
- Олон улсын ба үндэсний ТТБ-ууд
- Иргэний нийгэм, орон нутгийн байгууллагууд
- Хүний эрхийн байгууллага ба хүүхдийн эрх, хамгаалын чиглэлээр ажилладаг байгууллагууд
- Санхүү, төсөв болон эдийн засгийн хөгжлийн байгууллага
- Хувийн хэвшил, донор, сайн дурын байгууллагууд байхаас гадна судалгаа, шинжилгээ, бүртгэл, статистикийн байгууллага байж болно.

Хамтын ажиллагааг дэмжих санаачилга

Багийн гишүүдийн ихэнх нь үндсэн ажлынхаа хажуугаар Хамтарсан багийн үйл ажиллагаанд оролцдог тул тэднийг тогтмол, идэвхтэй, үр дүнтэй ажиллахад Засаг даргын хүчин чармайлт нэн чухал билээ. Иймд Хамтарсан багийн ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг урамшуулахад хэрэглэх дараах арга хэмжээг санал болгож байна:

- Салбарын яам, агентлагийн хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй холбоотой байж, шинээр гарч буй хууль эрх зүй, сайн туршлага, аргачлалын талаарх мэдээллийг цаг алдалгүй авч, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- Багаар ажиллахад тулгарч буй бэрхшээл болон доголдож буй асуудлыг хамтран хэлэлцэж шийдвэрлэх;
- Багийн гишүүдийн үндсэн байгууллагуудтай хамтарсан хурал, зөвлөгөөн, семинар, цахим уулзалт хийж мэдээлэл солилцох;
- Багийн гишүүдийн хамтын ажиллагаанаас гарсан үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг бий болгох;

- Хамтарсан багийн шинэ гишүүнд багийн бусад гишүүдтэй нэн даруй танилцуулж, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хамтарсан багийн гишүүдийг ажиллах өрөө, нөхцлөөр хангах талаар шуурхай арга хэмжээ авах.

ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх тайлан 21 дэх удаагийн илтгэлд Хамтарсан багийн хүний нөөц, ажлын нөхцлийн талаар цөөнгүй жишээ дурдсан байдгийг анхаарах хэрэгтэй.

1.1.ХАМТАРСАН БАГИЙН ХУРАЛ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн гишүүдийг гэр бүлийн хүчирхийллээс, хүүхдийг гэр бүлийн болон нийгмийн бусад орчинд хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, хохирогчид хуульд заасан үйлчилгээг үзүүлэх хамтарсан баг болон нэг цэгийн үйлчилгээний төв, хохирогчийг хамгаалах, түр хамгаалах байр ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан байна.

Хамтарсан багийн бүтэц, зорилгын талаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэгэнт тодорхой заагдсан тул хуулийн заалтыг давталгүй сум, баг, хорооны Засаг даргын ахалсан хамтарсан багийн үйл ажиллагааг хэрхэн үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг болох санааг дурдъя.

Хамтарсан багийн үйл ажиллагааг зохицуулан зангидах гол газар нь Хамтарсан багийн төлөвлөсөн болон шуурхай хуралдаан юм. Дээрх хуралдаануудыг багийн ахлагчийн хувьд Засаг дарга тогтмол хуралдуулах үүрэгтэй.

Хурлыг хэн нэгэнд хуралдуулахыг даалгах, багийн гишүүдийг өөрсдөө цуглаад хуралд гэх боломжгүй учир зөвхөн хурлын үеэр л Хамтарсан багийн гишүүдтэйгээ хамтран хүчирхийллийн тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлно. Хамтарсан багийн төлөвлөсөн хурал нь тогтсон цаг хугацаанд, харин шуурхай хуралдаан нөхцөл байдлыг үндэслэн шуурхай зарласнаар явагдах ба багийн хуралдаан 51-ээс дээш хувийн ирцтэй тохиолдолд хүчин төгөлдөр байна² гэж журамд заажээ.

Хамтарсан багийн гишүүдийн нас, хүйс, туршлага, цол зэрэг, ажилласан жил, цалин, урамшуулал зэрэг ялгаатай байдлыг харгалзан Сум, хорооны Засаг дарга та багийн үйл ажиллагааны хэтийн төлвийг тодорхойлж, гишүүдийг нийтлэг зүйл, зорилгод нэгтгэхэд илүү анхаарах хэрэг гарна. Албан байгууллагын хамт олон хэн нэгнийгээ байхгүй үед нөгөөгийнхээ ажлыг нөхөн гүйцэтгэж болдог бол Хамтарсан багийн хувьд энэ нь боломжгүй зүйл юм. Тэд зөвхөн өөрийн төлөөлж байгаа салбарын чиг үүргийн хүрээний үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлэх болно. Нийгмийн ажилтан цагдааг, цагдаагийн ажилтан эмнэлгийн ажилтныг орлох, эсвэл, өмнөөс нь шийдвэр гаргах бололцоогүй.

Багийн ахлагч гишүүдийнхээ мэргэшлийн олон талт байдал, хувь хүний төлөвшил хандлагыг тодорхойлж удирдах хэрэг гарна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хамтарсан багийн гишүүдийн чиг үүргийг тодорхойлсон³ байдаг ч тэд илүү ажил

² Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам батлах тухай А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаал

³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 24-27 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017.

хийх, илүү хариуцлага хүлээхээс зайлсхийх хандлагатай байж болох тул өөрчлөлт хийх нь чухал юм. Багийн хамтрагчдыгаа ойлгож, тэдэнд итгэж, урамшуулж, тусалж дэмжих нь багийн ахлагчийн үүрэг юм. Иймд:

- Хамтарсан багийн гишүүдийн ажилладаг үндсэн байгууллагын удирдлагатай ажил хэргийн найрсаг харилцаатай байх, гишүүдийн ажлын амжилтын талаар удирдлага, хамт олонд нь албан харилцааны хүрээнд мэдэгддэг байх;
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын талаар нэг зорилго, үзэл бодол, хандлагаар ажиллах орчныг бүрдүүлж, ярилцлага хийх, үйлчилгээ үзүүлэхэд таатай өрөө, тасалгаатай болгох;
- Хамтарсан багийн гишүүдийн ажлаа мэддэг, хариуцсан ажлаа сайн гүйцэтгэдэг байдлыг багийн гишүүд, хамт олон, иргэд, олон нийтийн дунд урамшуулж, нэр хүндийг нь өсгөх зэргээр дэмжих нь зүйтэй.

Хамтарсан баг эхэндээ тийм ч үр дүнтэй ажиллаж чадахгүй байж болно, бие биеэ хүлээн зөвшөөрөхгүй, хамтын ажиллагааны арга барилд хурдан дадахгүй байдаг нь багийн удирдлагын менежментийг оновчтой сонгож ажиллахыг шаардаж байдаг. Гэсэн хэдий ч шинэ гишүүдийг сургаж, дадлагажуулж, Хамтарсан багийн үйл ажиллагааг хэвийн явуулахад гишүүдийн тэгш оролцоог хангаж чадвал амжилттай ажиллах боломжтой. Үүний тулд зорилго, үйл ажиллагааны журмаа гишүүдийн оролцоотойгоор боловсруулж мөрдөх, гишүүд ээлж дараагаар багийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж тайланг хамтран хэлэлцэх нь хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэртэй.

Хамтарсан багийн хурлын өмнө Засаг дарга та

- Холбогдох журмын дагуу ирүүлсэн кэйсийн хураангуйтай танилцах, эрэмбэлэх, танилцуулгыг хянах (шаардлагатай бол хурлын өмнө ямар гишүүдийг байлцуулахыг тогтох);
- Гишүүдээс хэн нь хуралд бэлтгэхэд туслахыг тогтох, кэйсийн байдал, санаа зовоосон асуудал, багийн бусад гишүүдээс ямар тусламж хүсэх талаар санал гаргахыг нарийн бичгийн даргын хамт төлөвлөх;
- Хамтарсан багийн хурлын талаарх товч мэдээлэл, хэлэлцэх асуудлыг боломжтой бол гишүүдэд урьдчилан илгээх ёстой. Ингэхдээ мэдээллийн нууцлалыг чандлан хадгахад анхаарахыг сануулна.
- Хурлын өрөөг урьдчилан бэлдэнэ.

Хамтарсан багийн хурлын үеэр Засаг дарга та

- Хурлыг удирдах;
- Гарын үсэг зурах нууцлалын хүснэгт, кэйсийн хураангуй, бусад материалыг танилцуулах;
- Кэйсийн нууцлалын гэрээг хянах;
- Хэлэлцүүлгийн үндсэн дүрмийг тогтоох (Жишээ нь, үг хэлэхийн тулд гар өргөх, нэгнийхээ ярьсан зүйлийг буруутгахгүйг сануулах);
- Хамтарсан багийн хурлын тэмдэглэл хөтлөх загварыг ашиглах;
- Хүн хоорондын таагүй харилцаа байдаг бол зохицуулах;
- Багийн алдаанаас суралцаж алдаагаа засах туршлага болгох. Ж: Ахмад настнууд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнийг бүртгэх, шийдвэрлэх арга зүйтэй болох гм.

- Нууцлалыг хадгалах журмыг (жишээ нь, баримт бичгийг бүрдүүлэх, хадгалах, устгах гэх мэт) хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хамтарсан багийн ахлагч хурлын дараа Засаг дарга та

- Багийн гишүүд хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхийг лавлаж, хэрэгтэй үед дэмжлэг үзүүлэх;
- Кэйсийн талаарх мэдээллийг цахимд оруулах, өгөгдөлд хяналт болон явцад хяналт тавих;
- Кэйс шийдвэрлэлтийн цаг хугацаа баримтлагдаж буйд анхаарал хандуулах;
- Кэйсийг шуурхай хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх;
- Үр дүнгийн тайлан гаргах асуудлыг хуваарилах, хурлын тэмдэглэл хөтлөх журмын хэрэгжилтийг хянах гэх мэт.

Хамтарсан багийн хурлаас бусад үед

- Багийн гишүүдтэй шуурхай харилцах цахим групп бий болгож, мэдээллийг шуурхай солилцох;
- Хамтарсан багийн гишүүдэд зориулсан богино сургалтыг зохион байгуулж байх;
- Шинэ гишүүдийг хамтарсан багийн талаар мэдлэг, баримжаатай болгох;
- Хамтарсан багийн чиг үүргийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах;
- Иргэдийн хурал бусад арга хэмжээнд Хамтарсан багийг төлөөлөн оролцох.

Сум, хорооны Засаг дарга та олон салбарт ажилладаг, ялангуяа, босоо удирдлагатай байгууллагын мэргэжилтнүүдэд хамтарсан багийн гишүүдтэйгээ хамтын ажиллагааны зарчмыг баримтлан ажиллах хэрэгтэй.

Тиймээс багийн ахлагчийн гол үүрэг багаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Мөн багийн ахлагч дараах манлайллын чадвартай байх нь чухал. Үүнд:

- Өөрөөрөө үлгэрлэн манлайлах;
- Хамтарсан багийн гишүүдийн эв нэгдэл, багийн соёлыг төлөвшүүлэх;
- Гишүүдийн зорилго, үнэт зүйлийг хүлээн зөвшөөрөх;
- Тэгш оролцоог хангах;
- Хамтарсан багийн бүх гишүүдийг багийн ажилд тэгш оролцуулах, шуурхай харилцах аргыг сонгох;
- Найдвартай байдлыг дээдлэх;
- Багийн гишүүдийн үндсэн агентлагийн удирдлагуудад нөлөөлж сайн харилцаатай байх;
- Цаг ашиглах дадлыг эрхэмлэх;
- Хамтарсан багийн ажилд оролцох цаг гаргах;
- Удирдан чиглүүлэх ур чадвараа дээшлүүлэх;
- Багийн тогтвортой байдал, уламж чанарыг хадгалах;
- Найрсаг харилцааг дээдлэх;
- Хүнд нөхцөл байдлаас гарахад гишүүддээ туслах зэрэг болно.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын үүрэг Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх , салбар дундын зохицуулалтаар хангах үндсэн үүрэгтэй. Үүнд:

- Удирдлага зохион байгуулалтыг сайжруулах;
- Үйл ажиллагааны төлөвлөлтийг хянаж төсвийг батлах;
- Үйл ажиллагааны үр дүнг хянах;
- Үйл явцын хяналт- шинжилгээ, тайлагналтыг тогтмолжуулах;
- Хамтарсан багийг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах.



Хамтарсан багийн гишүүдийн урамшуулал

- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12.6 дахь заалтийн дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийсэн Хамтарсан багийн нийгмийн ажилтанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ын дагуу үндсэн цалин дээр урамшуулал тооцож олгоно⁴.
- Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлын бүрэлдэхүүнд үйлчилгээний файл нээхэд шаардлагатай бичиг хэргийн зардал, баримтжуулах, холбон зуучлах, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12.6-д заасан урамшуулал багтана⁵.
- Нөхцөл байдлын үнэлгээний дагуу үзүүлсэн үйлчилгээний тоогоор санхүүжилт тодорхойлогдоно⁶.

Дээрх хууль, журамд заасан урамшууллаас гадна Хамтарсан багийн ахлагч дараах урамшууллыг гишүүдтэйгээ хэлэлцэж санхүүжүүлтийг эрэлхийлэх боломжтой.

- Хамтарсан багийн гишүүдийн хамтын ажиллагааны хүчин чармайлтыг тооцох, үнэлэх;
- Хамтын ажиллагаанд хамтарсан багийн гишүүний зарцуулсан цагийг тооцох;
- Төлөвлөлт, харилцаа холбоо болон уулзалттай холбоотой гарсан зардлыг олгох;
- Судалгаа, тоо баримт цуглуулах болон дүн шинжилгээ хийхэд шаардлагатай зардал, бусад зүйлээр дэмжих.

Засаг дарга хамтарсан багийн гишүүддээ зөвлөн хэвшүүлэх зүйлс

- Хамтарсан багийн гишүүд нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг баримталж ажиллана.
- Хамтарсан багийн гишүүд өөрсдөө гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих, хүчирхийлэлтэй хэн ч эвлэрэх ёсгүй гэдэг хандлагыг хэвшүүлэх түгээх үүрэгтэй.
- Багийн гишүүд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар өөрөө мэдсэнээр түүнээс урьдчилан сэргийлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна.
- Шуурхай болон зорилтот эсвэл нэн яаралтай хэрэгжүүлж болох богино хугацааны арга хэмжээг урт хугацаанд тогтвортой үр дүн гаргаж болох арга хэмжээтэй хослуулан хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Гаргасан үр дүнгээ сурталчилснаар урт хугацааны эрхэм зорилгодоо хүрэх

⁴ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"

⁵ Мөн журам

⁶ Мөн журам

дэмжлэгийг авах боломжтой болно.

- Хамтарсан багийн гишүүн хүчирхийлэлд өртсөн хэнийг ч ялгаварлалгүй, нэр төрд нь халдахгүй нууцыг нь задлалгүй хандаж үйлчилгээ үзүүлнэ.

Хамтарсан багийн гишүүд хохирогчтой ярилцах, үйлчилгээ үзүүлэхэд нь Засаг дарга та дэмжиж ажиллаарай:



- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид, ялангуяа, эхний удаа хүчирхийллийн үеэр болсон явдлын талаар дэлгэрэнгүй ярихаас татгалзах шалтгаантай байж болно. Иймд хамтарсан багийн гишүүд хүлээцтэй байж, хохирогчийг шүүмжилсэн, буруутгасан, эсвэл хүчирхийлэгчийг дэмжсэн өнгө аястай үг хэрэглэж харьцахгүй байх ёстой.
- Хохирогчийн итгэж найдаж байсан хүн хүчирхийлэл үйлдэж, итгэлийг нь эвдэх тохиолдол элбэг гардаг тул үйлчилгээ үзүүлэгчийн зорилго, санаачлагад итгэхгүй байх тохиолдол бий гэдгийг анхааруулна.
- Хэрвээ хохирогч айдастай байвал Засаг дарга ярилцлагыг бүрмөсөн зогсоох, эсвэл дараа боломжтой үед нь үргэлжлүүлэх талаар хамтарсан багийн гишүүдэд сануулж байх хэрэгтэй.
- Ярилцлагын явцад насанд хүрсэн хохирогч болон хүүхэд биеийн хэлэмжээр айдас болгоомжлол, ядарч туйлдсанаа илэрхийлвэл ярилцлагыг зогсоох хэрэгтэйг мөн гишүүдэд сануулна.
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүчирхийлэгчтэйгээ эвлэрсэн байж болзошгүй. Хэрэв тийм байдал мэдэгдвэл тухайн хохирогч гэр бүлийн хүчирхийллийн хохирогч байхаа больсон гэсэн үг биш бөгөөд сайн дураараа хохирогч болж байсан гэсэн үг ч бас биш юм.
- Хохирогчид хүчирхийлэгчийг өөрт нь эсвэл гэр бүлийнхэнд нь муу зүйл хийж хариу авах байх гэж болгоомжлонбайнгын айдастай байдаг.
- Хамтарсан багийн гишүүд үйлчилгээ үзүүлэхдээ өөрсдөө аюултай, эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга төлөвлөнө.

Мөн хохирогчид хууль хэрэгжүүлэгчдээс ч айх шалтгаантай байж болно. Тэд иргэний бичиг баримтгүй, тухайн орон нутагт байнга орших суух тогтмол хаяггүй, эрхэлсэн ажилгүй, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдэг, хэрэг төвөгт орж байсан зэргээсээ айж байдаг ба энэ шалтгаанаар тэдэнд үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болохгүй.

1.2. ХАМТАРСАН БАГИЙН ХҮНИЙ НӨӨЦ

Хамтарсан багийн талаар хийгдсэн судалгаануудад сум багийн нийгмийн ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа талаар олонтаа дурдсан байна. Энэ нь нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт нь тодорхой бус, ажлын ачааллыг бүрэн тооцдоггүй, цалин бага, ажлын байрны тодорхойлолтод зааснаас илүү ажлыг дайчлан хийлгэдэг зэрэгтэй холбоотой талаар мөн дурджээ.



Шигтгээ 1. Хамтарсан багийн хүний нөөц

Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 6065 гишүүнтэй, 715 хамтарсан баг ажиллаж байна. Хамтарсан багт мэргэжлийн нийгмийн ажилтан байх зайлшгүй шаардлагатай байх боловч анхан шатны нэгж болох багийн нийгмийн ажилтнууд нь мэргэжлийн бус албан хаагч байх нь элбэг байна. Тухайлбал: Улсын хэмжээнд, 2021 оны байдлаар хамтарсан багт 678 нийгмийн ажилтан ажиллаж байгаагаас 259 буюу 38 хувь нь мэргэжлийн, 419 буюу 62 хувь нь мэргэжлийн бус байна гэж ХНХЯ-аас ХЭҮК-т албан бичгээр илгээсэн бол ХЭҮК-ын хяналт, үнэлгээнд хамрагдсан 40 хамтарсан багийн нийгмийн ажилтны 27 буюу 68 хувь нь малын эмч, улс төр судлаач, эдийн засагч, гадаад харилцааны ажилтан зэрэг мэргэжилтэй мэргэжлийн бус хүн байна. Энэ нь анхан шатны нэгж болох багт хүний нөөцийн хүрэлцээ муу мэргэжил, туршлага харгалзахгүй ажиллуулж байсантай холбоотой байна гэжээ⁷.

Иймд Засаг дарга та нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг тодорхой болгож, аймаг, сум бүр Засаг даргын Тамгын газрын бүтцэд нийгмийн ажилтны орон тоог заавал оруулж батлуулах хэрэгтэй. Мөн зарим орон нутагт хамтарсан багийн бүрэлдэхүүнийг батлахдаа хуульд заасны дагуу албан тушаалаар нь бус, тухайн албан хаагчийг нэр зааж томилсон нь тухайн мэргэжилтэн ажлаас чөлөөлөгдөх, шилжин томилогдох тохиолдолд орон тоо эзгүйрч, үйл ажиллагаа нь доголдоход хүрч байна.

Шигтгээ 2. Хамтарсан багийн хүний нөөцийн асуудал

"Хамтарсан багийн хүний нөөцийн чадавх, чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн, сургалт арга зүйн хэрэгцээ" судалгаанд 21 аймаг болон сумдын хамтарсан багийн 2,807 гишүүн оролцсон бөгөөд оролцогчдын 14 хувь нь 7-оос дээш жил, 9 хувь нь 5-6 жил, 23 хувь нь 3-4 жил, 54 хувь нь 1-2 жил хамтарсан багт ажиллаж байна гэсэн судалгааны үр дүн гарсан нь ХЭҮК-ын хяналт, үнэлгээтэй нийцэж байна⁸.

1.3.ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн халуун цэг дээр Хамтарсан багийн гишүүд нөхцөл байдлын үнэлгээ хийж ажилладаг. Тэдэнд хохиорогчийг хамгаалах ажлаас гадна өөрсдийн аюулгүй байдлыг хангах асуудал чухал. Үүнд:

- Хэл амаар доромжлуулах (хувь хүний хувьд нь болон болон ажил албан тушаалтай нь холбоотойгоор);
- Үйлчлүүлэгч архи уусан байх, агсан тавих, цохиулах, зодуулах;
- Буруутгах (гэр бүлийг нь салгах гэж байгаа хүн мэтээр гүтгэх, бурууг хамтарсан багийн гишүүдэд тохохыг оролдох нь элбэг);
- Гүтгэх (Үйлчилгээ үзүүлэхгүй байна гэх эсхүл өөрийг нь хүчирхийлсэн гэх мэтээр гүтгэх);
- Дарамтлах (дарга руу чинь хэлнэ, гомдол мэдүүлнэ, ТВ дуудна гэх мэтээр);
- Айлган сүрдүүлэх (ална шүү, хараана, бөөд хандна гэх мэтээр айлгах);
- Хууль бус санал тавих, хэрэг үүсгэхгүй байхыг хүсэх, мөнгө эд зүйл амлах;
- Нийгмийн сүлжээн дэх хувийн мэдээллийг нь ашиглан нэр хүндийг нь унагах;

⁷ ХЭҮК, Хүний эрхийн төлөв байдлын судалгаа, 2022 он

⁸ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 2021 он

- Эрэгтэй болон эмэгтэй хүний чинь хувьд янз бүрийн санал тавих зэрэг эрсдэл тохиолдож болно.

Мөн оройн цагаар ихэвчлэн хүчирхийлэл үйлдэгддэг бөгөөд нохойд уруулах, харанхуйд унах, бэртэх, эд зүйлээ дээрэмдүүлэх зэрэг тохиолдол гарах нь бий. Иймд Засаг дарга дараах аюулгүй ажиллагааны хяналтыг нөхцөл байдлын үнэлгээ хийх гишүүдээр бөглүүлж хянах нь зүйтэй.

Хүснэгт 1. Хамтарсан багийн гишүүдийн аюулгүй байдлын хяналтын хүснэгт

№	Багийн гишүүдээс асуух ба сануулах зүйлс	ТИЙМ	ҮГҮЙ	Тайлбар
1	Гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийхээр явахдаа хамтарсан багийн 2-оос доошгүй гишүүн явж байгаа эсэхийг лавлах (нөхцөл байдлын үнэлгээ хийх журмын дагуу)			
2	Гар утас нь нэгжтэй эсхүл гарах болон орох дуудлага хүлээн авах боломжтой эсэх. Шаардлагатай тохиолдолд хэнд хандаж, ямар тусламж хүсэх, утасны дугаар нь байгаа эсэх			
3	Гэр бүлд үнэлгээ хийхдээ тохиромжтой хувцаслах. Тохиромжтой гутал өмсөх. Нохой болон бусад амьтан дайрвал хаахуйц цүнх барьсан эсэх			
4	Очих гэр бүлд хүн архидан согтуурсан, мансуурсан бол уулзалтыг цуцлах ба шаардлагатай тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авахуулна гэдгээ мэдэж байгаа эсэх			
5	Нэн яаралтай үнэлгээ хийхээс бусад үед харанхуй болсон үед айлаар явахгүй байх.			
6	Бусад			

Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэхдээ

- Багийн гишүүдийг чадваржуулах хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх
- Хамтарсан багийн үйл ажиллагааны дараалал, тайлагналт, явцын хяналтын арга зүйг боловсронгуй болгон идэвхжүүлэх
- Хамтарсан багийн сайн туршлагыг нийтэд танилцуулах, урамшуулах зэрэг аргыг ашиглах боломжтой.

Салбар дундын зохицуулалтыг хангах

Төрийн бусад байгууллагын нэгэн адил босоо тогтолцоо Хамтарсан багийн хувьд мөн үйлчилж байдаг.

Хамтарсан баг нь сум, хороо, багийн түвшинд үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Хамтарсан багийнүйл ажиллагаа засаг захиргааны хэд хэдэн нэгжийн үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлэх шаардлага гардаг.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар орон нутагт нийгмийн үйлчилгээ үзүүлж буй агентлагуудын удирдлагатай хамтран хамтарсан багт тэдгээр байгууллагын ажилтан, албан хаагчдын ажиллах журам, ажлын хүрээ, хязгаарыг нарийвчлан тохирч зохицуулалт хийх үүргийг хүлээж байна. Хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдах үйлчлүүлэгч, үйлчилгээний төрөл, санхүүжилтийн эх үүсвэр зэргийг нарийн тодорхойлох үүрэгтэй.

Үйл ажиллагааны үр дүнг хянах

Хамтарсан багийн үйл ажиллагаа тавьсан зорилго, зорилтоо биелүүлсэн эсэхийг тодорхойлох нь цаашид авах арга хэмжээний үндэс суурь болно. Үйл ажиллагааны хэрэгжилтийн явцыг хамтарсан багийн удирдлага хянаж тайлагнана.



Хамтарсан багийн нарийн бичгийн даргаар суманд Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтэн, хороонд хөгжлийн нийгмийн ажилтан, багт багийн нийгмийн ажилтан ажиллах бөгөөд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт зааснаас гадна багийн гишүүдийн чиг үүргийг хуваарилах, оролцоо, үр дүнг хянах үүрэг хүлээдэг байна.

Хамтарсан багийн нийгмийн ажилтан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд заасан олон чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд 20 гаруй төрлийн судалгаа хөтөлж, хамтарсан багийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөх, тайлагнах, урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хохирогчид сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, хохирогчийг хамгаалах, шаардлагатай үйлчилгээнд хамруулах зэргээр хамтарсан багийн үйл ажиллагааны 80-90 хувийг дангаар гүйцэтгэж байна⁹

Үйл ажиллагааны төлөвлөлт

Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөлтийг жил, улирлаар хийх нь тохиромжтой. Төлөвлөлтийг хийхдээ өмнөх оны үр дүн, статистик мэдээлэл зэрэгт суурилагаас гадна дээд шатны байгууллагаас дэвшүүлсэн бодлого, зорилттой уялдуулах нь чухал юм. Хамтарсан багийн үйл ажиллагааны хамгийн гол чиглэл үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх асуудал бөгөөд үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөнөөс гадна асуудал бүрт кэйс менежментийн үйлчилгээний төлөвлөгөө гарган ажлаа хуваарилж хамтран ажиллана.

Үйл ажиллагааны зохион байгуулалт

Хамтарсан багийн гишүүдийн хамтарсан багт ажиллах, үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө, үйлчилгээний дараалал зэргийг нарийвчлан тогтоох нь үйл ажиллагааны зохион байгуулалт хийж ажиллахад чухал юм.

Хамтарсан багийн гишүүд ажлын байрны тодорхойлолтод заасан үндсэн ажлуудаас гадна цаг үеийн шийдвэрлэх ажлууд их байдаг. Иймээс ажлын цаг, ачааллыг Засаг дарга, тухайн гишүүний үндсэн байгууллагатай хамтран ярилцаж зохицуулах боломжтой байж болох юм.

Гэр бүлийн болон хүүхдийн хүчирхийллийн эсрэг шуурхай үйл ажиллагааг зохион байгуулах асуудал ч үүнд хамаарна.

Хамтарсан багийн үйл ажиллагааны хэрэгжилт, үйлчилгээ үзүүлэх

Засаг дарга багийн ахлагчийн хувьд дараах үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулна.

1. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;
2. Хүчирхийллийн болзошгүй эрсдэлийг илрүүлэх, мэдээлэх, шуурхай таслан зогсоох үйл ажиллагаа;
3. Хохирогчдод үйлчилгээ үзүүлэх;
4. Хохирогчийг хамгаалах;
5. Хохирогчийг нөхөн сэргээх;
6. Нийгмийн халамжийн болон бусад шаардлагатай үйлчилгээнд хамруулах үйл ажиллагаа зэрэг болно.

⁹ ХЭҮК, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл. 2022 он

Үйл явцын хяналт- шинжилгээ, тайлагналт

Хамтарсан багийн ахлагч тухайн багийн үйл ажиллагааны үр дүнд явцын хяналт-шинжилгээ хийх ажлыг сар, улирал, жилийн эцэст зохион байгуулна. Түүнчлэн үйлчилгээний үр дүн, статистик мэдээллийг хууль, тогтоомжид заасан хугацаанд гаргаж, холбогдох талуудад тайлагнах үүргийг хүлээнэ. Хамтарсан баг нь аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ажлын тайлангаа хагас, бүтэн жилээр хүргүүлэх үүргийг хүлээж байдаг.



Хамтарсан багийг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах

Хамтарсан багийн тогтвортой ажиллах хамгийн гол нөхцөл нь төсөв, санхүүжилтийн асуудал юм. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нь хамтарсан багт санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтарсан багийн үйл ажиллагаа, үйлчилгээний төсвийн төлөвлөлтийг урт, дунд, жилийн хугацаанд хийж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх үүргийг хүлээж байна.

"Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам"-д Хамтарсан багийн үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсөв, хуулиар зөвшөөрөгдөх бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр заасан.

Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг жил бүр тусгайлан төлөвлөн Төсвийн тухай хуулийн дагуу тухайн харьяалах шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ.

Хүснэгт 2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээнд шаардлагатай зардлыг шийдвэрлэх нь

Хариуцах байгууллага	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн заалт
УИХ	9.1.3.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган батлах;
Засгийн газар	10.1.2.төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авах;
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	12.2.1.харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусгуулах саналыг тухайн шатны Засаг даргад уламжлах;
Эрүүл мэндийн сайд	15.1.1.энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан нэг цэгийн үйлчилгээ, энэ хуулийн 38.1.2-т заасан сэтгэл заслын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх;
ИТХ	18.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;
Засаг дарга	19.1.4.орон нутгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон төлөвлөгөөний төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
	19.1.5.хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;

<p>ХНХЯ, ХЗДХЯ, ЭМЯ-ны хамтарсан Тушаалаар шинэчлэн батлагдсан Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам</p>	<p>Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөв, холбогдох салбарын төсөвт тусгаж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон.</p> <p>Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, хуулиар завшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.</p> <p>4.1.2. Хамтарсан багийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг аймаг, дүүргийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон төсөвт тусгаж, шийдвэрлэнэ.</p> <p>4.1.3. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасны дагуу хэлэлцэн батална.</p> <p>4.1.4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлсэн хамгааллын үйлчилгээний зардлыг үйлчилгээ тус бүрээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ыг үндэслэн тооцож, нийслэл, орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага санхүүжүүлнэ.</p> <p>4.1.5. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид /насанд хүрэгч/ үзүүлсэн хамгааллын үйлчилгээний зардлыг үйлчилгээ тус бүрээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ыг үндэслэн тооцож, холбогдох төрийн захиргааны байгууллага санхүүжүүлнэ.</p> <p>4.1.6. Санхүүжилтийг гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхүйлажиллагаа, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, бүртгэх, шалгах, хүчирхийллийг таслан зогсоох, үйлчлүүлэгчид нөхцөл байдлын үнэлгээ хийх, үнэлгээнд үндэслэн нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай бусад нарийн мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучлах, зорилтот урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх болон эдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг зохион байгуулахад зарцуулна.</p>
---	---

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүүхэд хамгааллын Хамтарсан багийн чиг үүргийг өргөтгөж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг бүхий Хамтарсан баг байхаар тодорхойлсон бөгөөд Хамтарсан багийн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэхийн хамт бүх шатны Засаг даргын үүрэг хариуцлага ч нэмэгдсэн байна.

Хамтарсан баг нь а/ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний гэр бүлд тусламж, үйлчилгээ, б/ хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах¹⁰, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх¹¹, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах¹² зэрэг үйлчилгээг үзүүлнэ.

Хуульд хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалахаас гадна хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсан, үл хайхарсан зэрэг хүчирхийллийг илрүүлж, тусгай хамгаалалтаар хангах асуудал туссан байна.

Зураг 2. Хүчирхийллийн зураглал¹³



¹⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017

¹¹ Мөн хуулийн 29 дүгээр зүйл

¹² Мөн хуулийн 30 дугаар зүйл

¹³ <https://whiteribbon.org.nz/home/campaigns/respectful-relationships/slide5/>

Хүүхэд хамгааллын үйлчилгээ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай хуулиудад хүүхэд хамгаалал, эрсдэлд өртсөн хүүхдийг хамгаалах талаар туссан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.1-д заасан хамтарсан баг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид тухайн хүүхдэд үзүүлэх шаардлагатай үйлчилгээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргаж, хуульд заасны дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэхээр хуульчлагджээ.

Үүний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан "Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам" нь аймаг, сум баг, дүүрэг, хороонд байгуулагдсан "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаанд тавих хяналтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон Хүүхэд хамгааллын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахтай холбоотой харилцааг зохицуулж байна.

Түүнчлэн ХЗДХЯ, ЭМЯ, БШУЯ-аас 30 гаруй журам, 1 стандартыг батлан хэрэгжүүлж иржээ.

Зураг 3. Гэр бүлийн хүчирхийлэйн хохирогчийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийн зураглал



Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 715 Хамтарсан баг нийт 6365 хүүхдийн хамгааллын кейс дээр ажилласан байна. Хамтарсан баг нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн дараах 7 төрлийн үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Аюулгүй байдлын үнэлгээ,
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ,
- Сэтгэл зүйн үйлчилгээ,
- Нийгмийн халамжийн үйлчилгээ,

- Эрх зүйн зөвлөлгөө үйлчилгээ,
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ,
- Холбон зуучлах үйлчилгээ зэрэг болно.

Хүүхэд зөвхөн гэр бүлийн хүчирхийллийн шууд болон дам хохирогч болсноороо хамгаалал, үйлчилгээ авахаас гадна хүүхдийг үл хайхрах байдалд оруулсан, хүүхэд бусад эрсдэлд орсон нөхцөлд мөн хамгаалал, үйлчилгээг үзүүлнэ.

Зөвлөмж

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ба хүүхэд хамгааллын зөрчлийг арилгах талаар зарим үйлчилгээг мэргэшсэн ТББ-уудтай гэрээлэн ажиллах нь үр дүнтэй байдаг.
- Хуулинд хэсгийн ахлагчдыг гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх үүрэг хүлээхээр оруулсан ч амьдрал дээр иргэд гэр бүлтэй хамгийн ойр ажилладаг хэсгийн ахлагчдын оролцоог орон нутгийнхаа онцлогт тохируулан татан оролцуулах, хамтарсан багийн дэргэд “Дэмжлэгийн бүлэг” байгуулж ажиллуулах г.м сайн туршлагыг ашиглах нь зүйтэй.
- Хамтарсан багийн гишүүдийн оролцоо идэвх муугаас болж, Хамтарсан багийн хурлыг зөвхөн Засаг дарга, нийгмийн ажилтан 2 хуралдан шийдвэр гаргадаг алдааг давтахгүйн тулд Хамтарсан багт ажилладаг бусад салбар, мэргэжлийн байгууллагын удирдлагад санал тавьж, ажлын үнэлгээнд оруулж, дүгнэх хөшүүрэг оруулж болох юм.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд

Тэдний ихэнхийг нөхөн сэргээж, хэвийн амьдралд нь буцаан оруулахад ганцаарчилсан дэмжлэг, хамгааллын үйлчилгээ шаардлагатай байдаг. Хүчирхийлэл нь бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн, үл хайхрах зэрэг хэлбэрүүдтэй.

Шигтгээ 3. Тоо баримтаас

Дэлхий дээр амьдарч буй нийт хүүхдүүдийн гуравны нэг нь өдөр бүр дарамт хүчирхийлэлтэй тулгарч байна. Дэлхийд 5 минут тутамд 1 хүүхэд хүчирхийллийн улмаас нас бардаг гэсэн тооцоолол бий. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөөх дэлхий түншлэл байгууллагын судалснаар 4 хүүхэд тутмын 1 нь, хүүхэд насныхаа туршид бие махбодын хүчирхийлэлд өртдөг, 4 охидын 1 нь, 13 хөвгүүний 1 нь бэлгийн хүчирхийлэлд өртдөг, 6 хүүхэд бүрийн 1 нь, зөрчил мөргөлдөөнтэй улс орон, бүс нутагт амьдарч хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах явдал зэрэг хүчирхийлэлд өртөх эмзэг байдал нь нэмэгдэж байдаг.

Хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах явдлын сөрөг нөлөө эрт илэрч хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, нийгэм-сэтгэл зүйн сайн сайхан байдалд нь урт хугацааны хор хөнөөл учруулж, хүүхдийг хөгжих, эрхээ эдлэхэд сөрөг нөлөө үзүүлдэг.

Хүүхэд хамгааллын тухай хуульд “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж санаатай болон санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг” хэлнэ гэж заасан¹⁴.

Гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал, мөлжлөгийн аливаа хэлбэрт өртсөн хүүхэд бүр хамгаалагдах эрхтэй бөгөөд эдгээр хүүхэдтэй зүй бусаар харьцах явдал, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн

¹⁴ Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл эхмтгэл, УБ., 2016.

хамгаалал шаардсан асуудал Хамтарсан багийн чиг үүрэгт ордог.

Шигтгээ 4. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжөөс

Хүүхдийн эрхийн хорооноос 2017 онд МУ-ын засгийн газарт өгсөн зөвлөмжийн 25 дугаарт “Хүүхэд хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх өндөр эрсдэлтэйгээс гадна боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх нь зөрчигдөж буй, сүм хийдэд шавилан сууж буй хүүхэд, эцэг эх нь гадаад болон дотоодод шилжин суурьшсны улмаас бусдын асрамжинд амьдардаг хүүхдүүд, дотуур байранд амьдардаг малчдын хүүхэд зэрэг эцэг эхийн хараа хяналтаас гадуур амьдарч буй хүүхдүүдийн тоо өндөр байгаад Хороо сэтгэл зовиносон хэвээр байна. Мөн гэрээсээ хол газарт, олон цагаар уул уурхайн салбарт ажилладагын улмаас хүүхдээ үл хайхралд оруулж буй эцэг эхчүүд болон өрх толгойлон амьдардаг хүүхдийн тоо нэмэгдэж буйд Хороо туйлын харамсаж байна” гээд 27 дугаар зөвлөмжийн (а) “асралт гэр бүл, үрчлэлт зэрэг гэр бүлд суурилсан хувилбарт үйлчилгээг орон нутагт нь түшиглэн үзүүлж буй хүчин чармайлтаа улам бэхжүүлэх; (б) хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчим, хэрэгцээнд суурилан хүүхдийг хувилбарт үйлчилгээнд хамруулах шаардлагатай эсэхийг тогтооход чиглэсэн шалгуур үзүүлэлт, хамгааллын арга хэрэгслээр хангахад анхаарах; (с) асрамж халамжийн газрын ажилтнуудын тоо, мэргэшсэн байдал, зэргийг багтаасан стандартыг гаргаж мөрдүүлэх, асрамж халамжийн газар болон бусад хувилбарт үйлчилгээ үзүүлэгчдийг тогтмол хяналт үнэлгээнд хамруулж тэнд байгаа хүүхдүүдийн нөхцөл байдлыг тогтмол шалгаж байх; зөвлөмжийг тус тус өгчээ¹⁵.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний улмаас хүүхдэд хүнд ноцтой бэртэл гэмтэл авсан бол хүүхдэд үзүүлэх эмнэлгийн болон шүүх эмнэлгийн шуурхай тусламж, үйлчилгээг сум, хорооны хамтарсан багийн гишүүд, түр хамгаалах байр, халамжийн төвийн ажилтан нь эрүүл мэндийн болон шүүх эмнэлгийн шуурхай тусламж үйлчилгээнд холбон зуучилна. Хүүхдийн амь насанд аюултай тохиолдолд өмчийн хэлбэр болон шатлал харгалзахгүйгээр хүүхдэд хамгийн ойрын эмнэлэг ямар нэг илгээх хуудас шаардахгүйгээр эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх ёстойг анхаарах хэрэгтэй¹⁶.

2.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХОХИРОГЧ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗУРАГЛАЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-д гэр бүл, хүүхэд хамгааллын дараах 3 түвшний үйлчилгээг үзүүлэхээр заасан. Үүнд:

- шуурхай тусламжийн үйлчилгээ
- хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ
- зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журамд заасны дагуу хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлээс хамгаалах, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хүүхдийг гэр бүл болон нийгмийн бүхий л орчинд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, санхүүжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар заасан¹⁷ тул Засаг дарга уг тушаалыг дэлгэрүүлэн үзэх нь зүйтэй.

¹⁵ <https://mlsp.gov.mn/content/detail/1084>

¹⁶ НҮБХЭХ-ноос Монгол улсын ХЭК-ийн хэрэгжилтийн 5 дахь илтгэлд өгсөн зөвлөмж, 2017 он

¹⁷ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А/218 дугаар тушаал <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389973129241>

Зураг 4. Шуурхай тусламжийн үйлчилгээний зураглал



Зураг 5. Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ

ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ	
КЭЙС МЕНЕЖМЕНТ	Гэр бүлийн орчинд хамгаалан, нөхөн сэргээхэд чиглэсэн үйлчилгээ
	Хүүхэд түүний гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ Кэйс менежмент
	Явуулын үйлчилгээ
	Сэтгэл засал, эмчилгээ
	Хууль эрх зүйн туслалцаа, үйлчилгээ
	Халамжийн үйлчилгээ
	Боловсролын үйлчилгээ
	Эрүүл мэндийн үйлчилгээ
	Хүүхдийг гэр бүлээс нь тусад нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ
	Түр байрлуулах хамгаалах үйлчилгээ
	Нэг цэгийн үйлчилгээ-түр хамгаалан байрлуулах үйлчилгээ
	Төвлөрсөн халамжийн үйлчилгээ
	Халамжийн хувилбарт үйлчилгээ
Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ	

Хүснэгт 3. Зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ

Зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ	
Хүүхдэд чиглэсэн Хүчирхийлэл, дээрэлхэлтээс сэргийлэх, зөрчил шийдэх, эерэг харилцаанд суралцах гэх мэт хөтөлбөр, нөлөөллийн ажил	Эцэг эх, хамгаалагчид чиглэсэн Эерэг хүмүүжлийн аргууд, хүүхдийн нас сэтгэхүйн, хөгжлийн онцлог, гэр бүлийн харилцаа гм чиглэлээрх хөтөлбөр, нөлөөллийн ажил
Олон нийтэд чиглэсэн: Хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хөтөлбөр, нөлөөллийн ажил	
Мэргэжлийн байгууллага, оролцогч талуудад чиглэсэн хөтөлбөр, нөлөөллийн ажил	Хүүхэд хамгааллын байгууллагын ажиллах хүчийг чадавхижуулах ажил

2.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хамтарсан багийн үйлчилгээ үзүүлэх хоёр дахь гол бүлэг бол гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрсэн хохирогчид, түүний гэр бүл юм.

Жендэрт суурилсан хүчирхийллийн нэг хэлбэр нь гэр бүлийн хүчирхийлэл бөгөөд ихэвчлэн дотнын хамтрагч үйлдэж, эмэгтэйчүүд хохирогч болж байдаг. Гэмт хэргийн албан ёсны статистикаас гадна манай улсад анх удаа 2017 онд хийсэн Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаанаас харахад ч энэ байдал батлагддаг.

Хохирогчдод үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй иргэн, жирэмсэн эмэгтэй, ахмад настны хэрэгцээ, шаардлагыг харгалзана. Монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ орчуулагч, хэлмэрчийн тусламж авах боломжоор хангана. Үйлчилгээ үзүүлэхдээ хохирогчдын нууцлалыг хадгална.

Хохирогчид үзүүлэх үйлчилгээг холбогдох байгууллага, албан тушаалтан хамтран үзүүлэхдээ үйлчилгээний талаарх мэдээллийг солилцох үүрэгтэй. Холбон зуучлах үйлчилгээ болон байгууллага хоорондын мэдээлэл, солилцоо нь хохирогч, даван туулагчийн зүгээс өөрт тохиолдсон зүйлээ олон дахин ярих эрсдлийг багасгаж, ингэснээр үйлчлүүлэгч сэтгэл зүйн цочролд дахин өртөхөөс урьдчилан сэргийлдэг.

Шигтгээ 5. Жендэрт суурилсан хүчирхийлэл судалгааны тайлангаас

Эрэгтэй хүнтэй дотно харьцаатай байсан, одоо байгаа эмэгтэйчүүдийн 57,7 хувь нь амьдралынхаа туршид хамтрагчийн хүчирхийллийн нэг болон хэд хэдэн хэлбэрт өртөж байжээ. Харин энэ хувь Хэнтий аймагт хамгийн өндөр 68,6 хувьтай байжээ.

Эмэгтэйчүүдийн 31,2 хувь нь хамтрагчийн хүчирхийлэлд амьдралдаа ямар нэг хэмжээгээр өртсөн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн шалтгааныг судалгаанд хамрагдагчдын 40 хувь нь архидалт, 13,9 хувь нь гэр бүлийн орчин, хүмүүжил, харилцаа хандлага, 10,9 хувь нь үл ойлголцол гэж хариулсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дөрвөн эмэгтэй тутмын нэг нь буюу 23,9 хувь нь цагдаад, арван эмэгтэй тутмын нэг буюу 13,2 хувь нь эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад, 12,5 хувь нь лам, шашны байгууллагад ханддаг гэж хариулсан бол хамгаалах байр болон бусад тусламж, үйлчилгээний байгууллагад маш бага буюу 1,5 хүртэлх хувь ханджээ.

Хамтарсан багийн гишүүд гэр бүлийн хүчирхийллийн талаар сайн мэдэж байх шаардлагатай тул тэднийг зайлшгүй сургалтанд хамруулж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Хамтарсан багийн гишүүдийн оролцоог тодорхой кэйсүүд дээр хэрхэн тодорхойлсныг харна уу.

Хүснэгт 4. Хамтарсан багийн гишүүдийн оролцоо¹⁸

Кейсийн тодорхой нөхцөлүүд	Тухайн кейс дээр ажиллах багийн гишүүд оролцоо
Хүүхэд эцэг, эх, асран хамгаалагчдаа зодуулж, хүнд гэмтэл авсан.	Засаг дарга багийг ахалж, удирдлагаар хангана. Нийгмийн ажилтан кейс менежер хийнэ. Хамтарсан багийн гишүүдээс: - Цагдаагийн байгууллагын ажилтан - Эмч - Өрхийн нийгмийн ажилтан голлон оролцоно.
4 хүүхэдтэй эмэгтэйг нөхөр нь архи уусан үедээ зодож, гэрээсээ хөөсөн учраас тэд хамаатны хүмүүсээ бараадан амьдарч байна. Хүүхдүүд нь цэцэрлэг, сургуульдаа явж чадахгүй байгаа.	Засаг дарга багийг ахалж, удирдлагаар хангана. Нийгмийн ажилтан кейс менежер хийнэ. Хамтарсан багийн гишүүдээс: - Цагдаагийн байгууллагын ажилтан - Халамжийн мэргэжилтэн/нийгмийн ажилтан - Сургуулийн нийгмийн ажилтан - Цэцэрлэгийн арга зүйч
70 настай, ахмад настан Болд болон Дулмаа хоёрын 5 хүүхэд нь ээж аавынхаа тэтгэврийг зээл тавиулж, авсан. Ахмадуудад хоол, эм авах мөнгө байхгүй тухайгаа нийгмийн ажилтандаа хэлж, улсын асрамжийн газар очиж болохыг асуусан.	Засаг дарга багийг ахалж, удирдлагаар хангана. Нийгмийн ажилтан кейс менежер хийнэ. Хамтарсан багийн гишүүдээс: - Цагдаагийн байгууллагын ажилтан - Халамжийн мэргэжилтэн/нийгмийн ажилтан - Өрхийн нийгмийн ажилтан
Хөгжлийн бэрхшээлтэй хүүг гудамжинд салхилж байх тухайн гудамжны хэсэг үеийн хүүхдүүд ирж доромжилсон, зодсон. Тухайн хүүхдүүд өмнө нь бүлэглэн бусад хүүхдүүдийг дээрэлхэж байсан гэсэн гомдол ирсэн.	Засаг дарга багийг ахалж, удирдлагаар хангана. Нийгмийн ажилтан кейс менежер хийнэ. Хамтарсан багийн гишүүдээс: - Цагдаагийн байгууллагын ажилтан - Сургуулийн нийгмийн ажилтан - Сургуулийн сэтгэл зүйчийг татан оролцуулж болох - Хүүхдүүдийн ангийн багш нартай хамтран ажиллах - Мэргэжлийн ТББ-уудтай хамтран ажиллах гэх мэт
Ганаа эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. Ганаа ажил хийхгүй бол болохгүй, ажлаа хийгээд явах үед эхнэр нь архидан согтуурч, хүүхдүүд нь хаягдаад байдаг. Энэ талаар зохицуулахыг оролдож Ганаа эхнэртэйгээ ярилцах үед нь эхнэр Ганааг зодож, архины шилээр толгой тус газар цохиж гэмтээсэн.	Засаг дарга багийг ахалж, удирдлагаар хангана. Нийгмийн ажилтан кейс менежер хийнэ. Хамтарсан багийн гишүүд: - Цагдаагийн байгууллагын ажилтан - Халамжийн нийгмийн ажилтан - Өрхийн нийгмийн ажилтан - ТББ-ын төлөөлөл - Эмч голлон оролцоно.

Насанд хүрсэн хохирогчтой ажиллах нь хүүхэдтэй ажиллахаас багагүй ажиллагаатай. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй иргэн байвал хэлмэрчлэх хүн хэрэг болно. Мөн өндөр настай хүмүүстэй болгоомжтой хандах хэрэгтэй тэд ихэвчлэн эдийн засгийн болон бие махбодын хүчирхийлэлд хохирсон байдаг ба кэйсийн нууцлалыг сайтар баримтлахгүй бол хүчирхийлэл давтан үйлдэгдэх эрсдэлтэй.

¹⁸ Э.Дуламсүрэн, Кэйс менежментийн гарын авлага, УБ.,2023

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Э.Дуламсүрэн, Кэйс менежментийн гарын авлага, УБ.,2023
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №5
3. Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2016
4. НҮБХЭХ-ноос Монгол улсын ХЭК-ийн хэрэгжилтийн 5 дахь илтгэлд өгсөн зөвлөмж, 2017 он
5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А/218 тоот тушаал, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам
6. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"
7. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам батлах тухай А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаал
8. Хүний эрхийн төлөв байдлын судалгаа, 2022 он
9. Хүний эрхийн үндэсний комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл, УБ.,2022 он
<https://mlsp.gov.mn/content/detail/1084>
<https://whiteribbon.org.nz/home/campaigns/respectful-relationships/slide5/>

